

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-19

1.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/	6-18
2.“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл	18-19

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
07 дугаар сарын 01-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 17 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Батлут, П.Мөнхтулга, З.Мэндсайхан, Б.Чойжилсүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хэлэлцэх асуудлын 4 дүгээрт орсон “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг хэлэлцэх асуудлын 3 дугаарт орсон Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох асуудлыг хойшлуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн хэлэлцэх асуудлын 2 дугаарт орсон Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, А.Энхбат, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер П.Чанцалдулам, Д.Энхдалай, Э.Энхбаатар, И.Эрдэнэцэцэг, В.Эрдэнэцогт, ахлах аудитор Ж.Бүжинханд, П.Батцэцэг, С.Бат-Эрдэнэ, Ж.Нямцэцэг, М.Пагмадулам, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, ахлах аудитор У.Оюунхүү, аудитор Б.Идэрбалжинням, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ч.Тавинжил, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Төлбөр, тооцооны хэлтсийн дарга Н.Саруул, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Алтанхорол, Б.Баяр-Эрдэнэ, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Хонгор, Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, мөн газрын Татварын орлогын газрын дарга С.Баярмаа, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалт, удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Л.Бямбажав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Ж.Ганбаатар, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 5
Бүгд: 20
75.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 58 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 10 цаг 15 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
9 цаг 17 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн ирж, хуралдааны ирц 52 хувьтай байна. Ирц хангалттай байгаа учраас Төсвийн байнгын хорооны 7 сарын 1-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хуралдаанаар, хуралдаанд ирсэн гишүүдээ танилцуулъя. Т.Аубакир, Б.Батцэцэг, П.Ганзориг, Аубакир гишүүн чинь бүртгүүлчихсэн юм байна шүү дээ, Б.Заяабал, Б.Түвшин, Р.Батболд, Х.Болормаа, Х.Ганхуяг, Б.Мөнхсоёл, Ж.Батжаргал, Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Г.Тэмүүлэн нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. 5 асуудал төлөвлөсөн байна. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 2 дахь хэлэлцүүлэг байгаа. 2 дахь асуудал Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 26, 27 оны төсвийн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байгаа, анхны хэлэлцүүлэг. 3-д Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гарсан иргэдийн өргөдлийн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлт. 4.Байнгын хорооны тогтоолын төсөл нөгөө ажлын хэсэг байгуулсныг хүчингүй болгож байгаа юу. Их Хурлын даргаас ажлын хэсэг байгуулчихсан байна, давхардсан. 5 байнгын хорооны тогтоолын төсөл “Засгийн газарт чиглэл өгөх тухай” гэсэн ийм 5 асуудал байна. Тийм таных. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Батжаргал гишүүн, өөр нэг гишүүн байх ёстой, Батжаргал гишүүн, Ганхуяг гишүүн. Би бас нэг горимын санал гаргаж байгаа. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолын төсөл ажлын хэсгийн хүрээнд бэлэн болчихсон. Гэхдээ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас тогтоолын тодорхой заалтууд дээр тодорхой тооцоо судалгаан дээр тулгуурлаж, нэмэлт найруулга өгөх шаардлага байна. Тэрүүнийгээ бид барьж, хөрөнгө оруулагч талтайгаа ярих асуудлууд байгаад, тэрэнд нэлээн дэм болох юм гэдэг ийм үүднээс хүсэлт тавиад байгаа юм. Тийм учраас Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолыг түр хойшлуулж өгөхийг өнөөдрийн хуралдаанаас хасаж, түр хойшлуулж өгөхийг хүсэж байна. Дээр нь тэр тогтоолыг өөрийг нь хаалттай гаргамааргүй, нээлттэй байдлаар гаргах эрх зүйн боломж байгаа эсэх талаар холбогдох байгууллагуудаас тодорхой лавлагаа хүссэн. Зарим газраас тодорхой албан бичгүүд ирсэн. Тэр дагуу холбогдох газруудаас шийдэл гаргуулж, нэг мөр ойлгох ийм шаардлага байгаад байна.

Ц.Даваасүрэн: 3 горимын санал гарах юм байна, нэг мөр хураачихъя. Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Хувь хүний орлогын албан татвартай холбоотой иргэдийн саналаар 1 хувийн татвартай холбоотой нэг санал, дүгнэлт гаргах ёстой байгаа. Өнөөдрийн хурлаар хэлэлцэх ёстой байсан боловч ажлын хэсгийн санал, дүгнэлт арайхан бэлэн болоогүй байна. Дараагийн Байнгын хорооны хурал дээр танилцуулж, санал хураалгахыг хүсэж байна.

Ц.Даваасүрэн: Ганхуяг гишүүний горимын саналыг ойлголоо. Би нэг горимын санал гаргаадахъя. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 26, 27 оны төсвийн төсөөллийг дагаад 26 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахаар ороод ирж байгаа шүү дээ. Энэ чинь хуулийн зөрчилтэй юм байна лээ. Яагаад гэвэл одоогийн хийж байгаа төсвийн тодотгол чинь ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсантай хийж байгаа, холбогдуулж хийж байгаа байхгүй юу. Тэгээд 26 оныхтой ямар ч хамааралгүй. Тэгэхээр гуя дагаж хүзүү гэдэг шиг дараа жилийнхээ төсвийн хүрээний мэдэгдлийг одоо өөрчлөх тухай асуудал яривал тодорхой хуулийн заалтууд, жишээлбэл Тогтвортой байдлын хуулийн 7.5, Хууль тогтоомжийн тухай хуулийн 41.9, хууль санаачлагчийн энэ эрх хэмжээний асуудлууд нь хуулийн зөрчилтэй байгаа учраас Төсвийн хүрээний мэдэгдлийг нэг өдөр хойшлуулж байж хэлэлцэхгүй бол болохгүй.

Нөгөө талаар 2 дахь өөрчлөлт нь энэ хэлэлцүүлгийн явцад зарим өөрчлөлтүүд гарчихсан байна. Нөгөө Төрийн албаны хууль энэ тэрийг татаад авчихсан байгаа шүү дээ. Тэрэнтэй холбогдолтойгоор Төсвийн хүрээний мэдэгдлээ Тогтвортой байдлын хуулийн хүрээнд нь зарим өөрчлөлтүүдийг эргэж харах ийм шаардлага байгаа учраас Төсвийн хүрээний мэдэгдлийг нэг өдрөөр, нэг өдрөөр билүү, хойшлуулахаар ийм горимын санал гаргаж байгаа. Болно, болно. Гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Өчигдөр ажлын хэсгийн хуралдаан дээр ярьж байгаад 25 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 26, 27 оны төсөөллийг ингээд явж болж байна гэж. Тэгэхдээ саяын таны хэлдгээр тодорхой тоонууд дээр өөрчлөлт орж байгаа учраас ухрааж хэлэлцэхэд болохгүй гэх юм байхгүй. Гэхдээ 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28 оны төсөөллийг буцаачих тухай асуудал яригдсан өчигдөр. Хэрвээ ингээд буцаачхаад Их Хурал завсарлаад явчихвал ЗГ 26 оны төсвөө боож чадахгүй болох юм байна лээ. Яагаад тэгж байна вэ гэхээр зэрэг 26 оны төсөв, одоо 25 оны төсвийн хүрээний мэдэгдэлд 26 оны төсөөллийг харахаар зэрэг хоорондоо алдагдал байхгүй, өнөө орлогын доод хэмжээ буюу босго заасан хэмжээ дахиад өөрчлөгдчихсөн ийм юмнууд байгаа учраас үүнийг харин яг хууль журмынх нь дагуу зохицуулалтыг нь зөв хийж өгч, шийдлийг нь гаргаж өгч байж Их Хурал завсарлахгүй бол энэ 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28 оны төсөөллийг зөв болгож өгөхгүй бол болохгүй юм байна лээ. Энэ төсвөө боож чадахгүй болох юм байна лээ шүү, энийг анзаарах ёстой гэж.

Ц.Даваасүрэн: Тийм, яах вэ тэгэхдээ тийм шалтгаан байгаа ч нөгөө Тогтвортой байдлын хуулийн тодорхой өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай юм байна лээ. Тэгэхээр наадах чинь ер нь хойшлуулж байж ярихгүй бол болохгүй болчихоод байна. Батжаргал гишүүний гаргасан горимын саналаар эхлээд санал хураана. Гишүүдээ санал хураалтдаа бэлтгэе, бэлтгээрэй. Гишүүдээ бэлэн болсон

уу? Би бас энэчээнээс та бүгдийнхийг үзээдэхье. Аубакир гишүүнийх орохгүй байна. Түвшин гишүүнийх бас, Түвшин гараад явчихсан юм уу? Батцэцэг сайдынх орохгүй байна. Манай Түвшин гишүүн чинь бүртгүүлчхээд гараад явчхав уу? Түвшин гишүүн, Аубакир гишүүн, Батцэцэг гишүүн гурвынхыг л оруулмаар байна горимд, орохгүй байна, одоо яасан? Түвшин өөрөө байхгүй учраас нөгөө бэлтгэл яагаагүй байгаа байхгүй юу. Батжаргал гишүүний гаргасан горимын саналын дагуу Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлыг хойшлуулъя гэсэн саналаар дэмжье гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 16 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 68,8 хувиар Батжаргал гишүүний горимын санал дэмжигдсэн байна.

Ганхуяг гишүүний гаргасан горимын саналын дагуу Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гарсан иргэдийн өргөдлийн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хойшлуулъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 70,6 хувиар Ганхуяг гишүүний горимын санал дэмжигдсэн байна.

Миний гаргасан горимын саналын дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 26, 27 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 26 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 27, 28 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг хойшлуулъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжигдэж, 76,5 хувиар Төсвийн хүрээний мэдэгдлийн хэлэлцүүлгийг нэг өдрөөр хойшлуулах санал дэмжигдлээ. Ингээд эдгээр саналууд дэмжигдсэн учраас дараагийн хэлэлцэх асуудлууддаа оръё.

Нэг.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Эхний хэлэлцэх асуудал. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 24 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг би та бүхэнд танилцуулъя. Б.Жавхлан Сангийн сайд, С.Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Ж.Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Л.Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, З.Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч, Ц.Наранчимэг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор, Д.Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор, Ж.Ганбат Монгол Улсын Сангийн яамны ТНБД, Р.Отгонжаргал Гаалийн ерөнхий газрын дарга, Ч.Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Б.Цогбадрах Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Ч.Тавинжил Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Бундхорол Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга, Н.Мөнхсүх

Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт тайлан, бүртгэлийн хэлтсийн дарга, П.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Л.Ичинноров Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга, Л.Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Б.Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Н.Саруул Сангийн яамны Төрийн сангийн газрын Төлбөр, тооцооны хэлтсийн дарга, П.Чанцалдулам Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Д.Энхдалай Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын менежер, Э.Энхбаатар Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Э.Эрдэнэцэцэг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын менежер, Б.Эрдэнэцогт Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Ж.Бүжинханд Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Ж.Нямцэцэг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн газрын ахлах аудитор, П.Батцэцэг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, С.Бат-Эрдэнэ Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, М.Пагмадулам Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Ю.Энхтуяа Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын менежер, аудитын гэж үг 4 орж байна шүү энд. У.Оюунхүү Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Б.Идэрбалжинням Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор, С.Баярмаа Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газрын дарга, Л.Бямбадорж Татварын ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Р.Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалт, удирдлага, арга зүйн газрын дарга, Б.Баяр-Эрдэнэ Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан, бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, М.Алтанхорол Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг оролцож байна.

Нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 24 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайд танилцуулъя. Тийм үү? Тэгвэл сайдыгаа дуудчих, хариулах асуудал гарна шүү дээ. Орлодог сайд нь хэн юм бэ, орлодог сайд нь хэн юм бэ? Сангийн сайдыг орлодог сайд нь хэн юм бэ, уг нь тэр нь л уншиж баймаар байгаа юм л даа, уг нь байдаг шүү дээ. Байдаг юм, угаасаа уламжлал болчихсон юу байдаг байхгүй юу. Яах вэ зүгээр сүүлийн үед нэг харагдаад байгаа юм ингээд яг өөрсдийнхөө асуудлыг оруулж байгаа үед сайдууд нь байхгүй, Төсвийн хүрээний мэдэгдэл орж байхад Эдийн засгийн эрхэлсэн Шадар сайд нь байхгүй ингээд байх юм. Үнэнийг хэлэхэд Дамдинням, Аубакир 2 бол өмнө нь сайд нь байхгүй байна гээд л гүрийгээд суугаад байдаг байсан юм. Одоо тэгсэн чинь харин сайдуудгүй хэлэлцчихье гээд л ингээд байж байна. Ингэж болохгүй шүү та нар, ингэж дороо эвдэрч ерөөсөө болохгүй.

Энэ чинь нөгөө Дэгийн тухай хууль дээр яг заалттай учраас би тэгээд байна л даа. Дэгийн тухай хууль дээр хар даа, ингэж танилцуулсан байгаа юм. Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дарга, тэгээд Үндэсний аудитын газрын Ерөнхий аудитор танилцуулгыг хийнэ гээд биччихсэн

байгаа учраас л би тэгээд байна. Тэгээд яах вэ нам болон бүлгийн хуралдаанд танилцуулах үүргийг энэ 2 хүн хүлээхээр хуульчилчихсан байгаа байхгүй юу. Үгүй ээ, үгүй хуулийн заалттай юм байна шүү дээ. Тэгэхээр яах юм бэ? Хуулийн заалттай юм байна шүү дээ. Үгүй. Жишээлбэл Ерөнхий аудитор танилцуулна гэж байхад би өөр хүнд танилцуулаад байж болохгүй шүү дээ. Хуулийн заалттай учраас тэгээд байна л даа.

Зүгээр нэг хуулийн танилцуулга бол хамаа алга. Түүн дээр чинь яг тэр сайд гэсэн юм байхгүй шүү дээ. Энэ дээр чинь болохоор Ерөнхий аудитор, Сангийн сайд гээд хоёуланг нь заагаад өгчихсөн учраас би тэгээд байна. Орлодог сайдаар уншуулна. Батцэцэг сайд. Энэ чинь сайд бүрийг орлож байгаа, байхгүй үед нь орлох сайдууд Засгийн газрын тогтоолоор байж байгаа шүү дээ. Батцэцэг сайд танилцуулъя.

Б.Батцэцэг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын чуулганы 6 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 онд 29 их наяд 670,8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 30 их наяд 591,1 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2 их наяд 451 тэрбум төгрөгөөр сайжирч, 920,2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ба сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулж ажиллалаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Үндэсний аудитын газар, Сангийн сайдын багцын 103 төсөвт байгууллага, 122 төсөл, сан, төрийн өмчийн 8 аж ахуйн нэгж, нийт 233 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Улсын төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 5 их наяд 81,8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, үүнээс урсгал зардалд 2 их наяд 723,6 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 2 их наяд 85,3 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд тус Байнгын хороонд харьяалагдах 2 төсвийн ерөнхийлөн захирагчийн 9 төсөл, арга хэмжээнд 277,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл 94,4 хувийн биелэлттэй байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлах Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Батцэцэг сайдад баярлалаа. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 24 оны санхүүгийн нэгдсэн тайланд

хийсэн аудитын тайланг Монгол Улсын ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна. 6 номерын микрофон.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын талаар тоймлон танилцуулъя. Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 206 тайлан, 19 данс нэгтгэгдсэнээс 93 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 132 байгууллага, 19 дансыг түүвэрт хамруулж, Горхимэлхий хад амралтын газар үйл ажиллагаа явуулаагүй гэсэн шалтгаанаар аудитад хамрагдаагүй байна. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй, харьяа 80 байгууллагад өөрчлөлтгүй, 13 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 55,6 тэрбум төгрөгийн 197 зөрчил илэрснээс 0,4 тэрбум төгрөгийн 28 төлбөрийн акт тогтоож, 43,1 тэрбум төгрөгийг төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 87 албан шаардлага, 12,1 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 79 нь зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлэн, 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн ба нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 608,7 тэрбум төгрөгийн 183 алдааг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар 161,9 тэрбум төгрөгийн 106 зөрчил илэрснээс 97,3 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 37 албан шаардлага, 62,8 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 63 зөвлөмж 1,8 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 6 албан шаардлагыг хүргүүлээд байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 733,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тайлант онд 293,6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 4 төсөл, арга хэмжээг 2024 онд шинээр төлөвлөж хэрэгжүүлсэн байна. Нийт төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж, 44,1 хувийн санхүүжилтийг олгожээ.

Дээр дурдсан аудитын дүн, дүгнэлтээс үндэслэн дараах асуудлуудад анхаарал хандуулахыг Үндэсний төрийн аудитын байгууллагаас санал болгож байна. Үүнд, 1 дүгээрт нь Үндэсний баялгийн санд эх үүсвэр төвлөрүүлж, хөрөнгө оруулалт хийж эхэлсэнтэй холбоотойгоор Ирээдүй өв сангийн хуульд заасан корпорац байгуулах, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх олгосон мандатыг боловсруулах бэлтгэл ажлыг эхлүүлж, хөрөнгө оруулалтын цэвэр орлогыг сангийн хөрөнгө оруулалтын өгөөжид суурилсан эрсдэлийн удирдлагатай уялдуулж, урт хугацаанд төсвийг тогтворжуулах бодлого боловсруулах. 2 дугаарт нь, ЗГ-ын нөөц сангаас зарцуулсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төслийн саналд тусгаж батлуулах. Төсвийн ерөнхийлөн захирагчдын тухайн жилийн төсөвт урьдчилан тооцож, төлөвлөн тусгах боломжтой зардлыг тус сангаас зарцуулахгүй байх. 3-д нь гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүйгээс өмнөх оноос нягтлан бодох бүртгэлийн алдаа 427,9 тэрбум

төгрөгөөр, санхүүгийн тайлангийн зөрчил 21,1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байгаад анхаарлаа хандуулах.

4-д нь төсөл, хөтөлбөрийн нэгжүүдийг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид шилжүүлэх, төслийн хэрэгжилт, гүйцэтгэл, хугацаа, тайлагналд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт хэрэгжүүлэх замаар үүрэг, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх. 5-д нь гадаад зээлээр санхүүжиж байгаа төсөл, хөтөлбөрийн мөнгөн урсгалыг бодитой төлөвлөж, зээлийн ашиглалт, өрийн менежментийг сайжруулах. 6-д нь олон жил үргэлжлэн хэрэгжиж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширсан шалтгаан нөхцөлийг судалж, төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, нэг мөр шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээ авч ажиллах. 7-д нь аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, цаашид алдаа, зөрчил гаргахгүй байхад анхаарах.

Түүнчлэн Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоол батлахтай холбогдуулан Төрийн аудитын байгууллагаас ЗГ-ын санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өгсөн хэрэгжилт хангалтгүй байгаа зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоолын төсөл санаачлан батлуулж, холбогдох байгууллагуудад чиглэл өгч, хэрэгжилтийг хангах, хяналтыг Улсын Их Хурлын холбогдох бүтцийн нэгжүүдийн хяналтад авхуулж, хамтарч ажиллах саналыг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд оруулж байгааг тус Байнгын хорооны гишүүд та бүхнээс дэмжиж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Ерөнхий аудитад баярлалаа. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаар Сангийн сайд, Ерөнхий аудиторын хийсэн танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Ганбаатар гишүүнээр, Да.Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүн асуултаа асууя. Цогтбаатар. Ж.Ганбаатар гишүүнийг нэмчих. Дарааллын дагуу Да.Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ аудитын дүгнэлттэй холбоотой чуулган дээр хэлж байхад сайд нарын ирц нэлээн хангалтгүй байсан. Одоо энэ дотор нэлээн олон алдаа дутагдлуудыг аудит гаргаад ирчихсэн байгаа. Тэгээд тэд нарыг нь энэ төсвийн ерөнхийлөн захирагчид сайд нартай нь ярья гэхээр сайдууд нь байхгүй, байгаа сайдууд нь энэ надад хамаагүй, тэр бусад харьяалагдаж байгаа байгууллагуудад нь хамаардаг юм байна лээ гэдэг юм яриад байдаг. Энэ дээр энэ ирцийг хангуулж өгөх талаас анхаарал хандуулах боломж байх уу? Жишээлэхэд энэ Сангийн сайдаас саяын Аудитын газрын Ерөнхий аудиторын дүгнэлтийг танилцуулсантай холбогдуулаад асуухад Сангийн сайдын харьяа байгууллагууд 206 байгууллагын 13 байгууллага нь хязгаарлалттай 4 дүгнэлттэй, 43 тэрбум төгрөгийн алдаа дутагдал яг энэ аудитын аудит хийж, хянаж шалгаж байх үеэр илэрснийг энэ засаж сайжруулж өглөө гээд байхад чинь Сангийн яаман дээр ийм алдаа дутагдал гараад байхад бусад яаман дээр хаана, ямар алдаа дутагдал санхүүгийн хувьд гарахыг энэ тайлан л илрүүлнэ үү гэхээс өөр бол хэн ч илрүүлэхээргүй болчихож байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ ядахдаа Хэрэг эрхлэхийн дарга эсвэл Сангийн сайдыг байлцуулж байж хэлэлцэхгүй бол бид ингээд нэг ярьсан болоод хэлбэр төдий л өнгөрөх гээд байна.

Тэгээд энэ Сангийн сайдын харьяалж байгаа байгууллагад л гэж би сая энэчээнээс сонслоо. 608 тэрбум төгрөгийн алдаа дутагдал энэ аудит хийж байх үед илэрсэн, түүнийг нь засаж сайжруул гэдэг ийм зөвлөмж тухайн үед нь өгөөд, алдаа дутагдлыг нь сайжруулаад явчихсан байна гэж ойлгож байна. Сангийн яаман дээр ийм алдаа дутагдалтай байхад Монгол Улс хэнээсээ, ямар хариуцлага, ямар мэргэжлийн хариуцлагыг хаанаас нэхэх вэ? Төсвийн байнгын хорооны даргаа. Би асуултад ингээд хариулах гэхээр хүн байхгүй. Тэнд зөндөө олон ажлын хэсэг.../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Жавхлан сайдыг дуудъя. Жавхлан сайдаас асуугаад байгаа юм байна.

Да.Цогтбаатар: Ядахдаа Хэрэг эрхлэхийн сайд эсвэл Эдийн засаг, хөгжлийн сайд ч юм уу мэргэжлийн нэг ч сайд байхгүй, энд бид санхүүгийн тайлан хэлэлцээд байгаа байхгүй юу.

Ц.Даваасүрэн: Хэрэг эрхлэхийн дарга, ер нь Сангийн сайд л даа. Хэрвээ Сангийн яамтай холбогдолтой асуугаад байгаа юм бол тийм ээ? Сангийн сайд яачхав? Яг өөрийнхөө асуудлыг ярьж байхад орж байхад байх хэрэгтэй шүү дээ. Энэ чинь манай дээр болохоор Сангийн сайд, яах вэ ер нь манай дээр бүх сайд байх хэрэгтэй л дээ болж өгвөл. Яагаад гэвэл салбар салбарын бүгдийнх нь л төсөв манай дээр яригдаж байгаа учраас. Алив Ганбат 8 номер, Сангийн сайд яачхав? 8 номерын микрофон юм байна.

Ж.Ганбат: Сангийн сайд нэг уулзалт хийгээд, удахгүй орж ирлээ гээд тэгж байна. Би энэ дээр хариулт дээр нь ийм байгаад байгаа юм. ЗГ-ын гадаад зээл, тусламжийн төслүүдийг Сангийн сайдын багц дээр явдаг. Энд яах вэ нөгөө хэрэгжилт нь яамнууд дээр байгаа, тайлан дээр нэгтгэж гарах нь Сангийн сайд дээр байдаг учраас энэтэй холбоотой Засгийн газрын гадаад зээл, тусламжаар 2024 онд хэрэгжсэн 138 төсөл, хөтөлбөрийн 24 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийтдээ 365,1 тэрбум төгрөгийн аудитыг ингээд явцад залруулгыг нь хийсэн. Мөн үүнд бий болсон хөрөнгийн үндсэн хөрөнгөдөө бүртгэх зэрэг техникийн шинж чанартай залруулгууд гол нь хийгдсэн. Яах вэ, ямар нэгэн хууль, журам зөрчсөн хууль бус үйлдэл үүнд байхгүй байсан. Үлдсэн 277,4 тэрбум төгрөгийн алдаа зөрчлийн дийлэнх нь 260 тэрбум төгрөг нь хэд хэдэн шалтгаантай байгаа. Үүнд эрүүл мэндийн 226 тэрбум төгрөг нь Эрүүл мэндийн яамны Монгол Улсад ковид 19 халдвараас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах бэлэн байдлыг хангах төслийн 20-оос 24 оны зээлийн ашиглалтын тооцоо нийлээгүй гэсэн ийм шалтгаанаар албан шаардлагыг аудитаас өгсөн байгаа. Гэхдээ энэ зээлийн ашиглалтыг жил бүр Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтэстэй тооцоо нийлж, барагдуулж ингээд баталгаажуулж явсан. Энэ талаараа холбогдох тайлбаруудыг нь өгч ажилласан байгаа.

Мөн НҮБ-ын Хүүхдийн сантай байгуулсан вакцины хүйтэн хэлхээний тоног, төхөөрөмж нийлүүлэх 2,9 сая ам.долларын гэрээний хүрээнд 2022 онд вакцины агуулахыг хүлээлгэн өгсөн байгаа. Төлбөрийн үлдэгдэл болох 1,6 тэрбум төгрөгийг 22 оны санхүүгийн тайланд тусган хаасан тул 24 оныг дахин тооцоо нийлэх шаардлагагүй гэдэг ийм тайлбарыг өгсөн байгаа. Мөн Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр Нийслэлд хэрэгжүүлж Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн хүрээнд 16,1 тэрбум

төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон боловч гүйцэтгэл нь 6 хувьтай байгаатай холбоотойгоор аудитаас албан шаардлага ирүүлсэн байгаа. Гэхдээ энд гэрээнд заасны дагуу урьдчилгаа төлбөр авсан бөгөөд техникийн нөхцөл шинэчилж авах зэрэг шалтгаанаар ажил удааширсан ийм байгаа. Тэгээд яах вэ мөнгө бол ямар нэгэн байдлаар санхүүгийн хувьд мөнгө эрсдэлд ороогүй ийм байдалтай байгаа.

Гол энэ гадаад зээлтэй холбоотой энэ төслүүдийн иймэрхүү нэг зөрчлүүдийн юмнуудыг аудит орох явцад залруулах энэ дээр юунууд өгсөн байгаа. Мөн Үндэсний аудитын газраас яг Сангийн сайдад гадаад зээлийн хэлэлцээрийг улсын төсвийн шингээх чадвар, хэрэгжих хугацаа, хөрөнгийн үр ашигтай уялдуулан төлөвлөж, ашиглаагүй эх үүсвэрээс үүсэх зардлыг бууруулах, тус арга хэмжээний хэрэгжилтийн хуваарьд суурилсан санхүүжилтийн зохицуулалтыг сайжруулах, дотоод хяналтаа бэхжүүлэх гэдэг ийм зөвлөмж өгсөн. Энэ дагуу бид холбогдох яамнуудад нь өгч байгаа. Тэгээд энэ гадаад зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүд дээр Үндэсний аудитын газраас болон тухайн нөгөө санхүүжүүлэгч олон улсын байгууллагуудаас давхар хяналт хийж, аудитад явж ингэж ажилладаг байгаа.

Ц.Даваасүрэн: Сангийн сайд хаана явна гэсэн чинь хариулчихлаа. Тэгэхдээ ингэе. Одоо ингээд хариулж байх хугацаанд Сангийн сайдыг дуудъя. Миний ойлгож байгаагаар энэ чинь танай гол асуудал шүү дээ. Тийм учраас тэгээд өөрөө байх хэрэгтэй, ажлаа зохицуулах хэрэгтэй. Байнгын хороотойгоо зэрэгцүүлээд уулзалт тавиад байж болохгүй шүү дээ. Эртээдийн хурал дээр уулзалттай байсан, одоо өнөөдөр бас уулзалттай. Тодруулах уу? Цогтбаатар гишүүн тодруулъя.

Да.Цогтбаатар: Хэрэг эрхлэхийн даргаас л асуух ёстой юм шиг байгаа юм энэ дээр. Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн энэ засаглал сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, тэгээд энэ төрийн өмчит компаниудын хувьцааг олон нийтэд нээлттэй арилжих, үйл ажиллагааг нь удаашралтай байгааг нь сайжруулах, ил тод болгох. Тэгээд бүр зарим тохиолдолд энэ дээр чинь хуулийн этгээдүүдийнхээ хэлбэрийг үнэн зөв ангилан бүртгээгүй, санхүүгийн тайланг нэгтгэлд хамруулаагүй байгаа нь төрийн өмч, хөрөнгө иж бүрэн илэрхийлэгдээгүй байна гээд байгаа юм. Энэ дээр ямар арга хэмжээ авч, яаж сайжруулж ажиллахаар байгаа вэ? Энэ ямар учраас иймэрхүү дүгнэлтүүд бичигдээд байгаа вэ гэдгийг Хэрэг эрхлэхийн сайдаас асуумаар, өөр хэнээс асуух вэ? Сангийн яам хариуцаад яваад байна гэж байхгүй.

Ц.Даваасүрэн: Хэн хариулах вэ? Гараа өргөө. Энэ чинь хариулах хүнгүй болчихоод байна уу, үгүй юү. Хэрэг эрхлэхийн даргыг дуудъя. Энэ мордохын хазгай гэдэг болж байна шүү ер нь. Ингээд дөнгөж шинээр байгуулагдангуутаа ингээд бухын хүзүү гаргаад байж болохгүй шүү дээ Их Хуралдаа. Тэр холбогдох сайд нараа дууд, дууд. Энэ чинь тэгээд 4 дэх өдөр гэхэд амжуулъя гээд, гишүүд харин энэ тодотголын асуудал дээр чинь харьцангуй энийг нь явуулаад өгье гэж хандаад байхад чинь өөрсдөө ингээд алга болчихоод байж болохгүй шүү. Сайдуудыг дуудчихъя. Тэгээд Цогтбаатар гишүүн дараа нь сайд нараас хариултаа авчихъя. Дараагийн хүн нь асуугаад явж байя. Ж.Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: 2024 оны төсөв ер нь 2016 оноос хойш бол хойших хамгийн сайн он жил болж өнгөрсөн л дөө. Ихэнх нь ашигтай гарсан. Сайн төлөвлөсөн үү, сайн ажилласан уу? Тэр хүнд, тэр үед ажиллаж байсан Засгийн газар их сайн

ажилласан учраас тэгээд их сайн гүйцэтгэлтэй байсан. Тэгэхдээ хэд хэдэн зүйл асууя. Энэ аудит энэ зэс хуулиараа уг нь заавал биржээр зарах ёстой. Аудитын даргаа 24 онд нэг л удаа зарсан. Уг нь энэ зэс биржээр зарвал улс орны эдийн засагт үзүүлэх нөлөөлөл маш өндөр. Намайг сайд болсны дараахан Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүх дарга тухайн үед энэ янз янзын Эрдэнэттэй холбоотой асуудлууд над дээр наалдаад байна, энэ зэсийг биржээр зарах ажлыг хурдлуулаач гэж хүсэлт тавьж байсан юм. Тэгээд өнөөдөр байхгүй таг чиг Ганбат даргаа. Зэс өөрөө өндөр үнэтэй байгаад байдаг, эрэлт маш өндөр байгаад байдаг. Нүүрс ярихлаар нүүрсийг их сонин, сонин юм ярих байх л даа. Нүүрс дээр өчнөөн мянган хариулт авчихсан.

Тэгээд нэг зүйл хэлэхэд ингээд 24 оны төсөв их ашигтай сайн гарахлаар 25 оныхоо төсвийг яахлаар 100 төгрөг олсон юм чинь дараа жил 200-г олно гээд ийм байдалтай төсөв баталсан учраас өнөөдөр ийм энэ байдалд хүрч байгаа юм. Тухайн үед орлого нь их байна гээд зөндөө ярьсан. Тэгээд шинэ гишүүдийг нөгөө нэг алдагдалгүй төсөв гэдгээр нэг сайхан толгойг нь эргүүлж байгаад, тэгээд баахан өндөр орлого тавьсан л даа. Тэгээд өндөр орлого тавиад, баахан зардал хийж авсан. Тэгээд нөгөө хэдэн гишүүд нь баахан нөгөө алдагдалгүй төсөв гэдгээрээ сайхан дарагдаад л, тэр өндөр орлогыг нь олж харахгүй, тэр нь засагдаагүй. Би тэгэхлээр аудитаас тэр асуулт ер нь нүүрс дээр ямар нэгэн алдаа дутагдал зөрчил 24 онд байсан уу? Бирж, нүүрс, зэс, төмөр, жонш, Биржийн тухай хуулийн биелэлт хэр байсан бэ гэсэн үг. Асуулт дууслаа.

Ц.Даваасүрэн: Хариулж байя. Цогтбаатар гишүүн байж байгаарай сайд нарыг дуудчихсан, одоо ороод ирнэ. 8 номер хариулах уу? Ганбат, хэнээс асуусан юм бэ? Ерөнхий аудитораас юм уу? 6 Ерөнхий аудитор.

С.Магнайсүрэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Биржийн хуулийн хэрэгжилт яг тухайлсан хуулийн хэрэгжилт гэдгээр нь манайх сэдэв, сэдэвчилсэн аудит хийгээгүй. Гүйцэтгэл, санхүүгийн аудитынхаа хүрээнд манайхан энэ талаар манай тайланд дурдагдсан. Биржийн хуулийн хэрэгжилт дээр манай тайланд орсон асуудлаар зэс дээр яг энэ биржээр зэс зарахтай холбоотой тэр олон улсын биржийн үнэлгээг авах, үнэлгээтэй холбоотой асуудал дээр манайхан зөвлөмж гаргасан байгаа, дүгнэлт гаргасан байгаа. Өөрөөр хэлбэл нүүрс бол гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрс дээр болж байна. Зэс дээр олон улсын нөгөө биржийн үнийг аваад ингээд нөгөө урт хугацаанд ингээд авчихаар энэ нь тодорхой богино хугацаанд орж ирж байгаа энэ биржид оролцогчдын ороод зэсийн арилжаа хийхэд зарим талаар учир дутагдалтай байна гэсэн ийм дүгнэлтийг гаргасан. Тэгээд энэ дүрэм журам дээр нь холбогдох өөрчлөлт орох, оруулах нь зүйтэй гэсэн ийм санал манайх гаргачихсан байж байгаа. Тэгээд энэ талаараа би танд дэлгэрэнгүй юу өгье, мэдээлэл өгье. Уул уурхайн сайд, Аж үйлдвэр, уул уурхайн сайд 2 дээр, 2-т.

Ц.Даваасүрэн: Ж.Ганбаатар гишүүн тодотгоё. Тэгээд дараа нь Бямбацогт сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Магнайсүрэн даргаа энэ төсөв дээр ер нь орлогыг өндөр тавиулахгүй байх талаас нь аудит ер нь сайн ярьж хэлж байх ёстой шүү, энийгээ цаашдаа сайн анхаарна биз дээ. Ер нь зөв төлөвлөх, орлого талдаа зөв төлөвлөх нь хамгийн чухал гэдгийг ойлгож байгаа байх. Наад зэс дээрээ буруу ойлголттой байна, та нарт аягүй бол нөлөөлсөн байх. Танай өмнөх дарга нарт, наад зэс чинь

шал буруу ойлголттой, буруу хариулттай байна шүү. Манай зэс чинь байна шүү дээ Лондоны бирж дээр зарагдаж байгаа зэсээс илүү эрэлттэй шүү. Орц найрлага, Хятадын үйлдвэрүүдийн авч байгаа байдал манайх хамаагүй өөр шүү. Манай зэс чинь шал, ер нь бараг Лондоны биржийн үнээс хэд дахин нь юу юм, нэлээн өндөр үнээр зарах бололцоотой зэс шүү.

Ц.Даваасүрэн: Санал хэлчихлээ. Цогтбаатар гишүүн дахиад тодруулчихъя Бямбацогт сайдаас асуусан асуултаа. Цогтбаатар гишүүний микрофоныг өгчихье. Байхгүй байсан учраас асуултыг нь дахиад асуулгачихъя.

Да.Цогтбаатар: Өмнөх хуралдаан дээр уг нь яг энэ асуудлыг ярьж байсан юм. Энэ төрийн өмчит компаниудын үйл ажиллагаа нийтэд ил тод биш, тэгээд үйл ажиллагаа нь удаашралтай, бүр хангалтгүй. Тэгээд энэ дээр энийг сайжруулах талаас нь бид энэ нэг ийм алдаа дутагдалтай явж байна, бид сайн бүртгэж чадахгүй байна, одоо бол бүр энэ нөгөө эд хөрөнгөө хүртэл бүртгэж чадахгүй, алдаа дутагдалтай бүртгэчихсэн байна гэдэг юм ярьж байгаа юм. Тэгээд би энэ дотор бүр таныг ороод ирсэн дээр жишээтэй ярихад Төрийн банк гээд арилжааны 12 банктайгаа цуг өрсөлдөөд явж байгаа Төрийн банкиг бид алдаа дутагдалтай нь ингээд өлгийдөөд боогоод яваад байх шаардлага байгаа юу? Төрийн банкны удирдлагууд жилд хэдэн зуун сая төгрөгийн цалин авч байгаа юм бэ? Дээрээс нь ашигтай ажиллалаа гээд хэдэн тэрбум төгрөгийн урамшуулал хувааж хүртэж байгаа юм бэ? Зүгээр төрөөс тэрбумтан төрдгийн тод жишээ Төрийн банк. Тэгээд бид энийг жишээлэхэд.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Хариулт дутуу байвал авна. Бямбацогт сайдад хариулъя. Төрийн өмчийн компаниудтай холбогдолтой асуулт байна.

С.Бямбацогт: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Төрийн өмчит компаниудын асуудлыг цэгцлэхээр энэ үе үеийн ЗГ-ын үед оролдоод, Улсын Их Хурлаас тодорхой тогтоол шийдвэр гаргаад, ЗГ-аас үйл ажиллагааны хөтөлбөрт суулгаад ингээд явж байгаа. Яг өнөөдрийн байдлаар Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын тухай хуулийг Улсын Их Хуралд өргөн барьсан. Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гарсан ажиллаж байгаа. Өнгөрсөн долоо хоногт Нийтийн өмчийн тухай хуулийг Их Хуралд ЗГ өргөн барьсан байгаа. Энэ ЗГ-ын, юу чуулган завсарлахаас өмнө хэлэлцэх эсэхийг нь шийдчихвэл энэ Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль, Төрийн нийтийн өмчийн тухай хууль хоёрыг нэгтгээд, ажлын хэсэг хэлэлцээд, ирэх намрын чуулганаар батлуулчихвал, үндсэндээ төрийн өмчит компаниудыг цэгцлэх, үйл ажиллагааг нь сайжруулах, ил тод болгох, бүтээмжийг нь нэмэгдүүлэх, үр ашигтай болгох энэ тал дээр нэг томоохон эрх зүйн боломж үүснэ гэж харж байгаа. Тэр болтол гэхдээ хүлээж суухгүй тодорхой ажлуудыг хийж.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Бямбацогт сайд, Бямбацогт сайдын микрофоныг өгье. 1 минут нэмчихье.

С.Бямбацогт: Тодорхой ажлын зураг авалтууд хийгдээд явагдаж байна. Өөрөөр хэлбэл төрийн өмчит компаниудаар Эрдэнэс Монгол компанийн доор уул уурхайн томоохон компаниудыг нэгтгээд үйл ажиллагааг нь сайжруулах, тодорхой ажлууд хийгдсэн, үр дүн гарч эхэлж байгаа. Яг үүнтэй адилхан Эрчис Монгол компанийн доор бусад аж ахуйн нэгжийг нэгтгэх, мөн цаашлаад төрийн өмчит 108 компанийг 70 болгож цөөлөх, ингэхдээ үйл ажиллагаа нь ил тод, бүтээмжтэй байх

энэ тал дээр тодорхой ажлууд хийхээр зорилт тавиад ажиллаж байгаа. Төрийн банкны тухайд Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтаж байгаа. Төрийн банкны үйл ажиллагааг хэрхэн сайжруулах бодлого, үйл ажиллагаа, менежментийг өөрчлөх талаар манай Сангийн яамныхан ТНБД Ганбат дарга хариулчих уу?

Ц.Даваасүрэн: 8.

Ж.Ганбат: Төрийн банк сүүлийн жилүүдэд Төрийн банкны ашиг байнга нэмэгдэж байгаа. Төрийн банкны үйл ажиллагаа тогтвортой, ил тод, нээлттэй болоод олон нийтийн оролцоог оруулж, хувьцаа эзэмшигчдийн гэж юу яачихсан ийм байдлаар Төрийн банкны үйл ажиллагааг явуулж байгаа. Цаашид Төрийн банкийг ЗГ-аас дундаж давхаргыг дэмжих, бичил бизнесийг дэмжих энэ чиглэлд нь түлхүү ажиллуулахаар ЗГ-аас шийдвэр гараад ингээд ажиллаж байгаа.

Ц.Даваасүрэн: Цогтбаатар сайд, гишүүн тодруулъя.

Да.Цогтбаатар: Бямбацогт сайд бол нэг Нийтийн өмчийн тухай хуулийг өргөн барьсан, төрийн өмчит компаниудыг цэгцлэх 2 хууль өргөн барьчихсан, намар болтол зүгээр суухгүй ажлаа хийгээд явж байгаа гэж хариулж байна. Тэгээд намар эргээд уулзах байх. Тэгээд тэр үед тодорхой үр дүнтэй уулзана гэж найдаж байгаа. Төрийн банкийг тухайлаад юу гэдэг юм ингээд нэг жижиг, дунд үйлдвэрийнхэнд зээл өгдөг банк одоогоороо ч биш шүү дээ. 5 хувийг нь нийтэд хувьцаа санал болгосон. Тэрүүгээр чинь жижиг хувьцаа эзэмшигчид нөгөө Төрийн банкных нь хувьцааны үнэ уначихсан, ашиг аваад, хүртээд байгаа нэг ч хүн байхгүй. Тэгээд тийм банкийг яаж сайн гэж хэлж чаддаг юм бэ? Төрийн банкны захирлууд чинь мэдээлэл албан бичгээр хүсье гэхээр ямар юмны нууцад хамаарч байна гээд мэдээллээ хүртэл өгөхгүй байгаа шүү дээ. Сангийн яамнаас ТУЗ-д нь дарга нь хүртэл суудаг, хэдэн дарга нар чинь тэгээд миний олж мэдэж байгаагаар бараг алцайж гишгэж чадахаа байчихсан. Гэрийнхээ яг хаалган дээрээс машинаар авхуулаад л, машинаар хүргүүлээд л явж байдаг залуучууд байж байсан. Одоо.../минут дуусав/

Ц.Даваасүрэн: Санал хэллээ. Бямбацогт сайд нэг юмыг анхаарахгүй бол сүүлийн үед энэ аудитын шалгалт хийхээр компаниуд байгууллагын нууц гэсэн юм яриад, тэгээд бүгдийг нь нууцаар хэлэлцдэг болох гээд байна шүү. Энийг нэг тагнуултай ярьж байж цэгцлэхгүй бол, байгууллагын нууц гээд өгчихдөг, тэгэнгүүт нөгөөдөх нь нууц болоод явчихдаг. Ялангуяа Оюу толгой түүн дээр их ажиллаж байна шүү дээ. Г.Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Байнгын хорооны даргаа ингээд оруулж ирж байгаа асуудлаа сайд нь өөрөө байхгүй бол хэлэлцэхээ болих хэрэгтэй. Өөрсдөө асуудлаа оруулж ирж байж хэлэлцэх хэрэгтэй шүү дээ. Тэгэхгүй хэн нэгэн сайд уншаад л, тэгээд яах вэ дээ төсвийн гүйцэтгэлээ хэлэлцэж чадахгүй л байна биз. Өнгөрсөн жил 23 оныхоо төсвийн гүйцэтгэлийг 8 сард хэлэлцэж л байсан шүү дээ хууль зөрчөөд. Тэгээд иймэрхүү юмнуудаа нээрээ болих хэрэгтэй. Яасан том толгойтой сайдууд байдаг юм. Энэ чинь Байнгын хорооны хурал зарлагдсан байхад уулзалттай гээд өөдөөс ингээд суугаад байдаг. Тэр аудитаас тэр гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн хяналт сул байна гэж. Мөнгөн урсгалыг нь бодитой төлөвлөх гэж энэ дээр яг ямар, ямар төслүүд байгаа юм бол, бодитой төлөвлөөгүйгээс болж ямар асуудал үүссэн юм бэ? Энийг дэлгэрэнгүй мэдээлэл

авъя. Ер нь хэчнээн, ямар дүнтэй, хэчнээн төслүүд энэ таны яригдаж байгаа асуудалд орж байгаа юм бэ? Магнайсүрэн даргаас.

Ц.Даваасүрэн: Хэн тодруулах юм бэ? Тийм, ер нь тэр мэдээллүүдийг нь гаргаад Г.Ганбаатар гишүүнд өгчих. Энэ бас яг өөрийнхөө асуудлыг хэлэлцэж байхад өөрсдөө оролцохгүй байна гэдэг буруу шүү Бямбацогт сайдаа. Энэ хууль дээр хэн танилцуулахыг нь заачихсан учраас орлуулахад их төвөгтэй болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд би сая яах вэ зүгээр Батцэцэг сайд орлодог байх гээд тэгээд танилцуулчихлаа. Тэгэхдээ яг энэ хуулийн хугацаанд батлагдах ёстой хуулиуд дээрээ өөрсдөө энд ирээд нэг хичээл зүтгэл гаргах хэрэгтэй шүү дээ сайд нар. Энэ гишүүдийн хэлээд байгаа буруу юм байхгүй байхгүй юу. Ингээд шаардаад байгаа нь. Энэ дээр 7 номер хариулах юм уу? Ер нь тэр өр зээлтэй холбогдолтой Ганбаатар гишүүний хэлээд байгаа юмыг Сангийн яамныхан гаргаад өгчих.

Ц.Наранчимэг: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна. Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад 28 төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан нэгтгэгдэж гарсан байгаа. Эдгээр 28 төсөл, хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаа нь харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч буюу сайд нартай явдаг. Санхүүгийн тайлангууд нь Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэгдэг учраас санхүүгийн тайлангийн аудитаар илэрч байгаа зөрчил нь Сангийн сайдын зөрчил дээр гарч байгаа юм. Нийт 28 төсөл, хөтөлбөрийн 593,7 тэрбум төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Үүнээс 13 төсөл, хөтөлбөрт хязгаарлалттай гэсэн санал, дүгнэлтийг өгсөн байгаа. Хязгаарлалттай гэсэн санал, дүгнэлтийг өгөхөд төсвийг үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, санхүүжилтийг урьдчилж олгосон, бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээгээ байгуулаагүй, төрийн өмчийн бодлого, шийдвэргүйгээр хөрөнгө бэлтгэсэн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг эдийн засгийн ангилалд зөрүүлэн зарцуулсан, түрээсийн төлбөрийг өндөр төлөвлөсөн, дотоод томилолтын зардлыг илүү зарцуулсан зэрэг ийм зөрчлүүд илэрснээс хязгаарлалттай санал, дүгнэлтийг хүргүүлсэн.

Сангийн сайдын төсвийн ерөнхийлөн захирагчдын Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд бид энэ нэгтгэгдэж байгаа энэ төслүүдийг харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч нь үйл ажиллагааг нь санхүүгийн үр дүнтэй нь нэг мөр хариуцаад явах нь зүйтэй юм байна гэсэн Төрийн аудитын байгууллагаас ийм дүгнэлтийг өгсөн байгаа.

Ц.Даваасүрэн: Ганбаатар гишүүн тодруулах уу? Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

Г.Ганбаатар: Тодруулах ч юу байх вэ, зүгээр ер нь яах вэ энэ мэдээллүүдийг нь бичгээр албан ёсоор авчихъя. Яг дэлгэрэнгүй мэдээллийг нь.

Ц.Даваасүрэн: Манай Байнгын хорооныхон яг энэ мэдээллийг нь аваад өгчхөөрэй, хяналт тавихгүй бол тэгээд өгнө гэххээд тэгээд өгөхгүй хоёрын хооронд юм өгсөн болоод өнгөрдөг шүү. Тийм учраас манай Байнгын хорооныхон анхаараад саяын Ганбаатар гишүүний асуусан мэдээллийг холбогдох газраас нь аваад өгье. 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлтэй холбогдолтой гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүн байвал нэр авъя? Мөнхсоёл гишүүнээр тасаллаа. Мөнхсоёл гишүүн үг хэлье.

Б.Мөнхсоёл: Ганцаараа үг хэлэх болчихож. Чуулган дээр ерөнхийдөө хэлсэн. Энэ Үндэсний аудитын газрын гаргаж байгаа тайланг сайн эргэлтэд оруулах буюу үнэ цэнийг нь нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Мөн түүнчлэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргаж байгаа сая сүүлд тодотгол дээр жишээлбэл тулгуу харьцангуй зөвлөмж бага харагдсан. Ер нь гаргаж байгаа тайлангуудыг сайн хармаар санагдсан. Тэгээд энэ зөрчил, алдаа дутагдал дээр нөгөө хариуцлагын тогтолцоо муу, хариуцах эзэнгүй болчихоор мянга тайлан гаргаад үр дүн багатай болчихоод байгаа байхгүй юу. Энийг нөгөө талыг нь харвал төсвийн тухайн жилүүдийн Төсвийн тухай хууль ч бай, төсөв тодотгох хэрэгцээ шаардлага ч бай бид боломжит хэмжээгээр нь танаж, хэмнээд, шаардлагатай хөрөнгө оруулалт ч гэдэг юм уу, урсгал зардлуудыг гаргахаар оруулаад, тодорхой байдлаар ойлголцоод дэмжээд явлаа гэхэд гадаа бол ард иргэд, олон нийт 1 дүгээрт мэдээлэл зарим талаар хомс, нөгөө талдаа энэ их алдаа дутагдал, оновчгүй зарцуулалт байгаа, хариуцах эзэнгүй яваад байгаа учраас итгэл муу, итгэлцэл доогуур. Тэгэхээр ямар ч юм урагшаа явахад хэцүү байгаад байгаа шүү.

Тэгээд энд ажил хийж байгаа бүх гишүүд энэ юуг нь хүртдэг, сөрөг байдлуудыг хамтдаа үүрдэг. Тэгэхээр энэ хариуцлагын механизм, хариуцах эзнийг тодорхой байлгах энэ тэр дээр нарийн сайн ажилламаар санагдаж байгаа. Тэгж байж бид бараг улс даяараа бүх асуудлыг шийдэхэд урагшлах байх. Тэгэхгүй бол энэ төсөвтэй холбоотой, төсвийн бодлоготой холбоотой бүх эргэн тойрон дахь зүйлүүд төлөвлөлтөөсөө өгсүүлээд, хэлэлцэх, батлах шат, тэр 4 шат чинь бүгдээрээ дор дороо асуудалтай байгаа учраас юм урагшлахад жоохон хүнд байгаад байна гэдэг үгийг хэлэх гэсэн юм. Тэгээд цаашдаа Булгантуяа Их Хурлын дэд даргын ахалж ажилласан төсөв ба цаглавар ажлын хэсгийн гаргасан хэсэг санал санаачилгууд Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, бусад холбогдох хуулиудад өөрчлөлт орсноор байдлыг бүр эрс төгс сайжруулахгүй юм гэхэд ахиулах байх гэсэн хүлээлт байгаа. Бас нэг миний эргэлзэж байгаа зүйл сая Булгантуяа даргатай зөвлөлдсөн. Бидний тэр өргөн барьсан тэр юунд төсөлд болохоор одоо Даваасүрэн дарга хариулах байх. Энэ Их Хурал дээр байгаа нөгөө судалгааны нэгж байна шүү дээ Эрдэнэсамбуу, тэрэнтэй, тэрийг яах вэ дараа нь ярья даа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлтэй нийлүүлэх гэж байгаа тэр хэсгийг.

Ц.Даваасүрэн: Ер нь төсвийн хариуцлага, сахилга батыг ярих цаг үе чинь өөрөө төсвийн гүйцэтгэл хэлэлцэх байхгүй юу. Гэтэл ингээд төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж байгаа явцыг ингээд харахаар жоохон ер нь жилээс жилд ингээд сулраад л яваад байгаа юм. Хуучин гишүүд нэлээн энэ дээр ач холбогдол өгч ингэж хэлэлцдэг. Ялангуяа аудитын тэр сөрөг зөвлөмж гаргасан юмнууд дээр нэлээн хатуухан ярьдаг байсан бол одоо бүүр ингээд сулраад явчхаад байгаа юм л даа. Тийм учраас энэ цаглаврууд ярихад бидний хамгийн гол анхаарах ёстой хэсэг чинь яг үнэн чанартаа энэ төсвийн гүйцэтгэл байгаа байхгүй юу. Гэтэл нөгөө хуулийн хугацаандаа шахагдаад, хаврын чуулгандаа амжиж батална, Их Хурал хууль зөрчихгүй байх гэдэг энэндээ шахагдаад аваачаад энэ хэлэлцүүлгийн явц нь жоохон суларчхаад байгаа ийм юм байгаа учраас бид энэ гүйцэтгэл хэлэлцэхийг нэлээн уртхан болгох, ажлын хэсэг гаргаж ажиллуулах энэ тэр гэсэн юмнууд дээр цаашдаа анхаарах шаардлагатай байх. Төсвийн гүйцэтгэлийн талаар Улсын Их Хурлын гишүүд үг хэлж, асуулт асууж дууслаа.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, 24 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай

Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн Батбаяр гишүүн танилцуулна, өөрөө танилцуулъя манай хорооны гишүүн юм чинь. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, ЗГ-ын 2024 оны санхүүгийн нэгдсэн болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

10.11 цаг

2 дахь асуудалдаа оръё. Энэ дараагийн асуудлуудыг маргааш хэлэлцэхэд сайд байна шүү.

Хоёр. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Байнгын хорооны тогтоолын төсөл хүчингүй болгох тухай асуудлыг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсантай холбоотойгоор Төсвийн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар баталсан Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хүчингүй болгох тухай тогтоолын төслийг боловсруулан та бүхэнд тараасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай гэсэн ийм тогтоол гарахаар төлөвлөсөн байгаа. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3.13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос тогтоох нь:

1. Ажлын хэсэг байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 17 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай. Энэ тогтоолыг 25 оны өдрөөс, гарсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоол байна. Энэ тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Гишүүдээ санал хураалтдаа бэлтгэе. Аубакир гишүүнээ таных орохгүй байна бэлэн байдалд, санал хураалтад бэлтгэе. Мөнхсоёл гишүүн ороогүй байна, санал хураалтаа бэлтгэе. Пүрэвдаваа гишүүн гараад явчихсан юм уу? Аубакир гишүүн энэ 2 байгаа юм байна, орохгүй байх юм, болчихлоо. Санал хураалт явуулъя гишүүдээ.

Байнгын хорооны тогтоолыг хүчингүй болгох тухай Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 20 гишүүнээс, 20 гишүүн оролцсоноос 15 гишүүн дэмжиж, 75 хувиар Тогтоол хүчингүй болгох тухай тогтоолын төсөл дэмжигдсэн байна.

10.15 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа, баярлалаа гишүүдээ. Дараагийн хуралдаанд холбогдох сайдуудыг байлцуулахад Тамгын газрынхан анхааръя. Холбогдох асуудалтай сайдууд шүү. Маргааш өглөө 9 цагаас Зарлагын хяналтын дэд хороо хуралдахаар байгаа. Тийм учраас Зарлагын хяналтын дэд хороонд Сангийн сайд байлцана шүү.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

